



2013 оны 4 сарын 17
(14-р хэвлэл)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ Э-СОНИН

Мэдээний тойм:

- “Говийн ноён нуруу” ХХК-ийг гишүүнээр элсүүлээ
- “Голомт секюритиз” ХХК өдөр тутмын арилжаанд өөрийн оффисоос оролцож эхэллээ
- Үнэт цаасны арилжааны мэдээ
- Монголын хөрөнгийн биржийн 2013 оны I улирлын үнэт цаасны арилжааны мэдээ

“Говийн ноён нуруу” ХХК-ийг Монголын хөрөнгийн биржийн гишүүн компаниар элсүүлээ

Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 06 тоот тогтоолоор “Говийн ноён нуруу” ХХК-ийг Монголын хөрөнгийн биржийн гишүүн компаниар элсүүлээ. Ингэснээр Монголын хөрөнгийн биржийн гишүүн компанийн тоо 83-т хүрээд байна.


“Голомт секюритиз” брокер дилерийн компани өдөр тутмын арилжаанд өөрийн оффисоос оролцож эхэллээ

Монголын хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн бирж групп болон Төрийн өмчийн хороо хамтран дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилго бүхий “Ажлын мастер гэрээ”-г үзэглэн стратеги болон менежментийн түвшинд

хамтран ажиллаж эхэлснээс хойш Милленниум Ай Ти цогц системийг 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Төлбөр тооцооны Т+3 аргачлалын хамтаар зах зээлд нэвтрүүлсэн зэрэг олон ажлуудыг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн гүйцэтгэж ирсэн билээ. Тус системийн давуу талуудын нэг болох зайнаас арилжаанд оролцох технологийн шийдэл, дэд бүтцийг бэлэн болгож брокерууд тус тусын оффисоос өдөр тутмын арилжаанд оролцох боломж нээгдсэн тухай мэдээллэж байсан билээ.

“Голомт секюритиз” ХХК брокер дилерийн компани өөрийн ажлын байрнаасаа арилжаанд оролцох гэрээг 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Монголын хөрөнгийн биржтэй үзэглэснээр өөрийн оффис дээрээс арилжаанд оролцогч анхны компани болж 4 дүгээр сарын 4-нөөс алсаас арилжаанд оролцож эхлээд байна. Брокер дилерийн компаниудын хувьд өөрийн оффис дээрээсээ арилжаанд оролцох нь хөрөнгө оруулагчдад зах зээлийн талаарх мэдээ, мэдээллийг хурдан шуурхай хүргэх, цаг хугацаа хэмнэх зэрэг олон давуу талтай юм.

TOP-20 индекс



2013 оны 4 дүгээр сарын 1-нээс 15-ны хооронд нийт 11 удаагийн арилжаа явагдаж, 65 компанийн 1.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 3.4 сая ширхэг хувьцаа арилжсан байна.

Тус хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Хай би ойл” ХК /512.7 сая.төг/, “Талх чихэр” ХК /227.5 сая.төг/ “Би ди сек” ХК /98.1 сая.төг/ байсан байна.

Үнэт цаасны арилжааны мэдээ

Хувьцааны арилжаа: 4 дүгээр сарын 1-нээс 15-ны хооронд

| | |
|----------------------------|----------------|
| Арилжаа явагдсан өдөр | 11 |
| Арилжигдсан ширхэг | 3.4 сая |
| Арилжигдсан дүн | 1.1 тэрбум.төг |
| Арилжигдсан компанийн тоо | 65 |
| Нийт хийгдсэн хэлцлийн тоо | 655 |
| Өдрийн дундаж | 103.8 сая.төг |

| | |
|----------------------|--|
| Хамгийн их Өсөлттэй: | Глобал монголиа холдинг /HML / +101.09% |
| | Зоос гоёл /ZOO / +44.44% |
| | Бишрэлт индустриал /HNC / +29.39% |

Бууралттай:

| | |
|---------------------|---------|
| Увс чацаргана /CHR/ | -31.65% |
| Бэрх уул /BEU / | -25.23% |
| Таван толгой /TTL / | -20.00% |

| | |
|----------------------|-----------------------|
| Зах зээлийн үнэлгээ: | 1,460.5 тэрбум.төг |
| | 1.02 тэрбум ам.доллар |

TOP-20 индексийн өөрчлөлт: 14,897.53 / -4,1%




МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ Э-СОНИН

Монголын хөрөнгийн биржийн 2013 оны I улирлын
үнэт цаасны арилжааны мэдээ

Хувьцааны арилжаа

2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар нийт 61 удаагийн арилжаагаар 110 компанийн 14.2 сая ширхэг хувьцааг 8.7 тэрбум төгрөгөөр арилжсан байна. I-р улиралд 110 компанийн үнэт цаас арилжигдсанаас 53 компанийн үнэт цаасны ханш өсч, 44 компанийн үнэт цаасны ханш буурч, 13 компанийн үнэт цаасны ханш тогтмол байсан байна.



Зах зээлийн үнэлгээ

Зах зээлийн нийт үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 461.6 тэрбум төгрөгөөр буюу 22.8 хувиар буурч, 1 их наяд 564.4 тэрбум төгрөг боллоо.



Тайлант хугацаанд ТОП-20 индексийн үзүүлэлт

- дээд 18,301.93 нэгж
- доод 15,542.24 нэгж
- дундаж 17,310.49 нэгж

ТОП-20 индексийг оны эхэн үетэй харьцуулахад 12.5 хувиар буурч 15,542.24 нэгж болсон байна.

Багцын арилжаа

Тайлант хугацаанд Монинжбар, Дархан нэхий, Говь, Монголиа Девелопмент Ресорсис зэрэг ХК-ийн багцын арилжаа явагдаж, нийт 4 үнэт цаасны 6.2 сая ширхэг хувьцааг 4.4 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 50.6%-ийг эзэлж байна.

ИДЭВХИТЭЙ АРИЛЖААЛАГДСАН ҮНЭТ ЦААС

| ҮНЭТ ЦААС | АРИЛЖИГДСАН ШИРХЭГ | Эрэмбэ | ҮНЭТ ЦААС | ҮНИЙН ДҮН |
|-----------------------------|--------------------|--------|----------------------|------------------|
| МОНИНЖБАР | 5,193,392 | 1 | МОНИНЖБАР | 1,562,790,615.00 |
| РЕМИКОН | 2,488,113 | 2 | ДАРХАН НЭХИЙ | 1,320,910,980.00 |
| ХАЙ БИ ОЙЛ | 1,797,436 | 3 | ГОВЬ | 1,021,686,380.00 |
| ГЕРМЕС ЦЕНТР | 988,774 | 4 | МОНГОЛИА Д. РЕСОРСЕС | 863,991,663.00 |
| МОНГОЛИА Д.РЕСОРСЕС | 959,914 | 5 | ЕВРОФЁ АЗИА | 815,335,380.00 |
| ОЛЛОО | 523,119 | 6 | АПУ | 550,946,743.00 |
| НАКО ТҮЛШ | 394,746 | 7 | РЕМИКОН | 472,952,890.00 |
| ЕВРОФЁ АЗИА | 230,986 | 8 | ШАРЫН ГОЛ | 384,025,635.00 |
| ГОВЬ | 215,369 | 9 | ХАЙ БИ ОЙЛ | 318,164,041.00 |
| ДАРХАН НЭХИЙ | 167,881 | 10 | ТАВАН ТОЛГОЙ | 177,446,175.00 |
| Э-ТРАНС ЛОЖИСТИКС | 147,633 | 11 | БИ ДИ СЕК | 149,062,481.00 |
| ЖЕНКО ТУР БЮРО | 145,778 | 12 | БАГАНУУР | 119,329,665.00 |
| СИЛИКАТ | 145,482 | 13 | ГЕРМЕС ЦЕНТР | 102,591,039.00 |
| АПУ | 144,398 | 14 | НАКО ТҮЛШ | 90,316,164.00 |
| ХӨХ ГАН | 87,756 | 15 | БИШРЭЛТ ИНДАСТРИАЛ | 82,762,684.00 |
| ГОВЬФАЙНЕНШЛ ГРУПП | 86,024 | 16 | БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ | 63,675,300.00 |
| БАЯНХАЙРХАН ХК | 83,319 | 17 | ОЛЛОО | 55,407,199.00 |
| УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР | 54,928 | 18 | АДУУН ЧУЛУУН | 42,927,059.00 |
| БИШРЭЛТ ИНДАСТРИАЛ | 46,599 | 19 | ТАЛХ ЧИХЭР | 39,482,860.00 |
| БИ ДИ СЕК | 42,254 | 20 | ГУТАЛ | 36,516,895.00 |
| ШАРЫН ГОЛ | 39,880 | 21 | ЗООС ГОЁЛ | 33,567,855.00 |
| ЗООС ГОЁЛ | 32,030 | 22 | БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ | 28,497,070.00 |
| АДУУН ЧУЛУУН | 27,576 | 23 | СИЛИКАТ | 28,361,655.00 |
| БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ | 25,930 | 24 | ГАЗАР СУЛЖМЭЛ | 26,615,710.00 |
| БАГАНУУР | 22,815 | 25 | М. ЦАХИЛГААН ХОЛБОО | 23,325,900.00 |
| Нийт | 14,092,132 | | | 8,410,690,038 |
| Нийтэд зах зээлд эзлэх хувь | 98.65 | | | 94.61 |